



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/473

Булган сум

┌ Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ┐
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2021 оны III/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт нэгдсэн арга хэмжээг 16 сум 1 тосгонд зохион байгуулсугай.

2. “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3.500.000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийг “Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулан ажиллахыг Цагдаагийн газар (Г.Ганбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  В.АРИУН-ЭРДЭНЭ

6324010612